



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Гурванбулаг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/1/СТА-ТТЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Баянхонгор хот

2020 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын захирал бөгөөд  
тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 70442584

Цахим хаяг: [munkhbatb@audit.gov.mn](mailto:munkhbatb@audit.gov.mn)

Аудитын менежер: А.Цээням

Утас: 70442424

Цахим хаяг: [tseenyama@audit.gov.mn](mailto:tseenyama@audit.gov.mn)

Ахлах аудитор: Б.Должмаа

Утас: 88119345

Цахим хаяг: [doljmaab@audit.gov.mn](mailto:doljmaab@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	5
2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	6
2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт .....	7
2.8.1 Мөнгөн хөрөнгө.....	7
2.8.2 Авлага .....	7
2.8.3 Бараа материал .....	8
2.8.7 Үндсэн хөрөнгө .....	8
2.8.8 Өр төлбөр.....	9
2.8.9 Засгийн газрын хувь оролцоо.....	10
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	13
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	13
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	14
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	14
4. Менежментийн захидал .....	15
3.1 БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ.....	15
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	18
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан .....	18
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	19
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	21
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	23
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	23
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	25

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан

## 1. Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,  
Баянхонгор сум, Номгон баг  
Утас, факс 7044 2584  
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г  
ГУРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ  
ДАРГА Ц.ЭНХБОЛД ТАНАА

2020.03.23 № 1/380  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г Аудитын гэрчилгээ Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2, 8.9.3-т заасны дагуу Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Гурванбулаг сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Гурванбулаг сумын Засаг даргын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

005020318

томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Үүрэг хариуцлага

Гурванбулаг сумын Засаг дарга нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

## 2. Аудитын тайлан

### 2.1. Оршил

Гурванбулаг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Ц.Энхболд танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2, 8.9.3-т заасны дагуу Гурванбулаг сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гурванбулаг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 20-ноос 2020 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэв.

Гурванбулаг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 06 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.-

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

## 2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Гурванбулаг сумын Засаг даргын харьяаны төсвийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн судалгаанаас харахад Соёлын төвөөс бусад төсөвт байгууллагуудад нягтлан бодогч нарын бэлтгэж гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашиглаж, тайланг гаргаж байгаа бөгөөд цаашид бодлогын баримт бичгийг шинэчлэх шаардлагатай гэж үзсэн байна.

Гурванбулаг сумын Засаг даргын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Гурванбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд тайлант онд Татварын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалт хийгээгүй байна.

Төрийн аудитын байгууллагаас эрх асуудлын хүрээний байгууллагад санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр				
		Санал дүгнэлт гаргасан	Түүвэрлэсэн	Итгэл үзүүлсэн	Гэрээгээр хийлгэсэн	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	4	4	-	2	-
2	ТБӨӨААН	-	-	-	-	-
	Дүн	4	4	-	2	-

## 2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Гурванбулаг сумын Засаг даргын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг аудитор гүйцэтгэлээ.

Гурванбулаг сумын Засаг дарга санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Засгийн газрын санхүүгийн "Э-тайлан" программ хангамж ашигладаг байна.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 12 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзэн 2018 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1909146.7 мянган төгрөгийн 1.0 хувь буюу 19091.5 мянган төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2115139.6 мянган төгрөгийн 1.0 хувь буюу 21151.4

мянган төгрөгөөр тооцсон бөгөөд төлөвлөлтийн шатанд тооцсон материаллаг байдлаас 2059.9 мянган төгрөгөөр өссөн нь төлөвлөлтийн шатанд 2018 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг татсантай холбоотой байна.

## 2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

### Хүснэгт 1. ТШЗ-ийн СТА-ын мэдээлэл

№	Байгууллагын нэр	Аудит хийсэн байгууллагын нэр	Дүгнэлтийн хэлбэр	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгайн сангийн нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 8 байгууллага аудитад хамрагдсан байна.
1	ЗДТГ	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар	Зөрчилгүй	
2	Эрүүл мэндийн төв		Зөрчилгүй	
3	Ерөнхий боловсролын сургууль	"Глобал капитал" ХХК	Зөрчилгүй	
4	Цэцэрлэг		Зөрчилгүй	
5	ИТХ	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар	Түүвэртт хамрагдсан	
6	Соёлын төв		Түүвэртт хамрагдсан	
7	Орон нутгийн хөгжлийн сан		Түүвэртт хамрагдсан	
8	Сум хөгжүүлэх сан		Түүвэртт хамрагдсан	

### Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн эхний, эцсийн үлдэгдлийг тулган шалгахад нэгдсэн тайланд харьяа байгууллагуудын аудитлагдсан санхүүгийн тайлангаар нэгтгээгүй, эхний үлдэгдлийг Э-тайланд зөрүүтэй оруулсан зэргээс шалтгаалж, аудитын явцад дараах 253163.5 мянган төгрөгийн алдаа илэрснээс санхүүгийн байдлын тайланд 93890.6 мянга, үр дүнгийн тайланд 134164.1 мянга, мөнгөн гүйлгээний тайланд 450.0 мянга, төсвийн гүйцэтгэлийн тайланд 24658.8 мянган төгрөгийн алдааг залруулав.

### Хүснэгт 2. Э-тайланд ТШЗ-ийн зөрүүтэй оруулсан алдааны нэгтгэл

№	Байгууллагын нэр	Дансны нэр	Мөнгөн дүн	№	Байгууллагын нэр	Дансны нэр	Мөнгөн дүн
1	Ерөнхий боловсролын сургууль	Үр дүнгийн тайлан	27164.1	4	ОНХС	Үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан	107000.0
		Төсвийн гүйцэтгэлийн тайлан	24658.8				
		ЕБС-ийн дүн	51822.9				
2	ЗДТГ	Бараа материал/ аж ахуй	1008.0	5	Соёлын төв	Байдлын тайлан	1016.4
		Бараа материал/ бичиг хэрэг	47.0				
		Хөрөнгийн дажин үнэлгээ	82853.3	6	Эрүүл мэндийн төв	Үндсэн хөрөнгө/ машин тоног төхөөрөмж	8440.0
		ЗДТГ-ын дүн	83908.3			Үндсэн хөрөнгө/ Тавилга	500.0
3	ИТХ	Бараа материал/Бичиг хэрэг	26.0			Мөнгөн гүйлгээ	450.0
		ИТХ-ын дүн	26.0			Эрүүл мэндийн төвийн дүн	9390.0

Иймд цаашид байгууллагуудын аудитлагдсан санхүүгийн тайланг Э-тайланд үнэн зөв оруулж байх шаардлагатай тул менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

Сумын Засаг даргын харьяаны байгууллагуудын 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар 100.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна.

*Хүснэгт 3. Төсвийн шууд захирагчийн тайланд илэрсэн алдаа, зөрчил /сая төг/*

№	Байгууллагын нэр	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Санхүүгийн тайланд залруулах		Нийт	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ИТХурал					1	3			1	3
2	ЗДТГ					3	10.74			3	10.74
3	Соёлын төв					4	12.29			4	12.29
4	Сум хөгжүүлэх сан	1	42.6							1	42.6
5	Ерөнхий боловсролын сургууль							1	27.4	1	27.4
6	Цэцэрлэг							2	4.5	2	4.5
	<b>Дүн</b>	<b>1</b>	<b>42.6</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>8</b>	<b>26.03</b>	<b>3</b>	<b>31.9</b>	<b>12</b>	<b>100.53</b>

**2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт**

**2.8.1 Мөнгөн хөрөнгө**

Төрийн сан дахь мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 53782.4 мянга, эцсийн үлдэгдэл 115237.4 мянган төгрөг болж, 61455.0 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 4. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Эцсийн үлдэгдлийн эзлэх хувь
Орон нутгийн ерөнхий орлого	6598.9	54617.4	48018.5	47.4%
ОНХС	18043.2	6105.9	-11937.3	5.3%
Сум хөгжүүлэх сан	29140.3	54514.1	25373.8	47.3%
<b>Дүн</b>	<b>53782.4</b>	<b>115237.4</b>	<b>61455.0</b>	<b>100%</b>

*Эх сурвалж: Гурванбулаг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Орон нутгийн ерөнхий орлогын дансанд 54167.3 мянган төгрөгийн үлдэгдэл байгаагаас 24794.3 мянган төгрөг нь оны эцэст төсөвт байгууллагуудын төвлөрүүлсэн үлдэгдэл, 29373.0 мянган төгрөг нь урьд оны зарцуулаагүй үлдэгдэл байна.

**2.8.2 Авлага**

Авлага өмнөх оноос 84512.3 мянган төгрөгөөр өсч, оны эцэст 272937.2 мянган төгрөг болсон байна.

*Хүснэгт 5. Авлагын үлдэгдэл /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	2526.4	1567.3	-959.1
Байгууллагаас авах авлага	5353.9	3751.7	-1602.2
Хувь хүмүүсээс авах авлага	22000.0	129000.0	107000.0
Зээлийн хүүгийн авлага	158544.6	138618.2	-19926.4
<b>Дүн</b>	<b>188424.6</b>	<b>272937.2</b>	<b>84512.3</b>

*Эх сурвалж: Гурванбулаг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Авлага өмнөх оноос 84512.3 мянган төгрөгөөр өссөний гол шалтгаан нь сумын ОНХС-ийн хөрөнгөөс өмнөх онуудад малжуулах зээлийг олгож, бүртгээгүй байсан зөрчил ОНХС-ийн зарцуулалтад хийсэн гүйцэтгэлийн аудитаар илэрч, албан шаардлагын дагуу 107000.0 мянган төгрөгийн авлагыг нэмж бүртгэсэнтэй холбоотой байна.

Авлагын үлдэгдлийг аудитаар судалж үзэхэд олон жилийн насжилттай дараах авлага байна. Үүнд:

1. Ерөнхий боловсролын сургуулийн 2002 онд үүссэн 572.2 мянган төгрөгийн авлага нь сургуульд нярваар ажиллаж Батсүхтэй холбоотой, 2016 онд үүссэн 300.0 мянган төгрөг нь цалингийн урьдчилгаа авсан тэтгэвэрт гарсан Должинтой холбоотой;
2. Эрүүл мэндийн төвийн 2013 онд үүссэн 157.3 мянган төгрөгийн авлага нь байгууллагад ажиллаж байсан Д.Болормаатай;
3. Иргэдийн төлөөлөгчийн хурлын өмнөх оны 3000.0 мянган төгрөгийн авлага нь 2004-2008 онд сумын ИТХ-ын даргаар ажиллаж байсан Цэдэндамбаатай холбоотой;

### 2.8.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 174339.4 мянга, эцсийн үлдэгдэл 231428.7 мянган төгрөг болж, 57089.3 мянган төгрөгөөр өссөн байна.

#### Хүснэгт 6. Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	45,213.0	58,517.6	13,304.6
Эм боох материал	-	1,346.9	1,346.9
Бэлэн бүтээгдэхүүн	-	118.8	118.8
Бичиг хэргийн материал	7,340.6	11,246.2	3,905.6
Аж ахуйн материал	98,102.3	123,172.5	25,070.2
Түлш, шатах тослох материал	3,002.5	12,448.9	9,446.4
Хүнсний материал	1,103.9	517.8	(586.2)
Барилгын засварын материал	1,252.0	4,235.0	2,983.0
Мал амьтад	18,325.0	19,825.0	1,500.0
<b>Дүн</b>	<b>174,339.4</b>	<b>231,428.7</b>	<b>57,089.3</b>

Эх сурвалж: Гурванбулаг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд хандив тусламжаар 20963.0 мянга, төсвийн хөрөнгөөр 343668.6 мянган төгрөгийн бараа материал авч, 3205.9 мянган төгрөгийн бараа материал акталж, 304336.4 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

#### Хүснэгт 7. Байгууллагуудын бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/

№	Байгууллагын нэр	Бараа материал							
		Эхний үлдэгдэл	Төсвийн хөрөнгөөр	Хандив тусламжаар	БҮГД	Худалдсан, зарцуулсан	Акталсан	БҮГД	Эцсийн үлдэгдэл
1	ИТХурал	1,081.3	8,398.5	-	8,398.5	8,456.5	-	8,456.5	1,023.3
2	ЗДТГазар	21,982.5	46,100.9	12,715.0	58,815.9	44,045.0	3,205.9	47,250.9	33,547.5
3	Сургууль	76,681.0	134,343.7	-	134,343.7	106,600.0	-	106,600.0	104,424.6
4	Цэцэрлэг	33,874.2	57,351.3	6,488.0	63,839.3	54,359.9	-	54,359.9	43,353.6
5	Соёл	9,575.0	22,598.6	-	22,598.6	18,000.2	-	18,000.2	14,173.4
6	ЭМТөв	31,145.4	74,875.7	1,760.0	76,635.7	72,874.8	-	72,874.8	34,906.3
	<b>ДҮН</b>	<b>174,339.4</b>	<b>343,668.6</b>	<b>20,963.0</b>	<b>364,631.6</b>	<b>304,336.4</b>	<b>3,205.9</b>	<b>307,542.3</b>	<b>231,428.7</b>

### 2.8.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 4722503.4 мянга, эцсийн үлдэгдэл 4724215.1 мянган төгрөг болж, 1711.6 мянган төгрөгөөр өссөн байна.

#### Хүснэгт 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	3,435,176.9	3,338,691.5	(96,485.4)
Тээврийн хэрэгсэл	249,117.9	325,274.8	76,156.9
Машин тоног төхөөрөмж	494,330.9	482,622.5	(11,708.3)
Тавилга эд хогшил	244,254.9	253,264.3	9,009.4
Дуусаагүй барилга, байгууламж	20,000.0	23,770.0	3,770.0
Номын фонд	17,795.8	19,290.0	1,494.2
Бусад үндсэн хөрөнгө	190,390.0	210,589.9	20,199.9
Программ хангамж	3,195.0	2,470.0	(725.0)
Бусад биет бус хөрөнгө	68,242.0	68,242.0	-
<b>Дүн</b>	<b>4,722,503.4</b>	<b>4,724,215.1</b>	<b>1,711.6</b>

Эх сурвалж: Гурванбулаг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

**Хүснэгт 9. Байгууллагуудын үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/**

№	Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Төсвийн болон өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр худалдаж авсан	Үнэ төлбөргүй хандив, тусламжаар авсан	Акталсан	Эцсийн үлдэгдэл
1	Сургууль	1,183,594.0	49,659.4	-	23,519.4	1,209,734.0
2	Цэцэрлэг	937,199.7	8,924.0	-	833.2	945,290.5
3	Эрүүл мэндийн төв	662,171.5	13,170.0	8,940.0	45,639.9	638,641.5
4	Соёлын төв	51,243.4	3,115.0	28,000.0	4,428.0	77,930.5
5	ИТХ	11,662.7	-	-	171.6	11,491.1
6	ЗДТГ	1,876,632.2	50,020.0	141,864.5	227,389.2	1,841,127.5
	<b>Дүн</b>	<b>4,722,503.4</b>	<b>124,888.4</b>	<b>178,804.5</b>	<b>301,981.2</b>	<b>4,724,215.1</b>

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 124888.38 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, үнэ төлбөргүй хандиваар 178804.5 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн ба 301981.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталж хасагдсан байна.

**2.8.8 Өр төлбөр**

Нийт өр төлбөрт урт хугацаат зээл байхгүй, богино хугацаат өр төлбөрийн эхний үлдэгдэл 4858.1 мянга, эцсийн үлдэгдэл 5243.5 мянган төгрөг болж, 385.4 мянган төгрөгөөр өссөн байна.

**Хүснэгт 10. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Богино хугацаат өр төлбөр дүн	4858.1	5243.5	385.4
Ажилчидтай холбогдсон өглөг	3527.5	4080.2	552.7
Байгууллагад төлөх өглөг	1330.6	1163.3	-167.3
Урт хугацаат өр төлбөр дүн	0	0	0
<b>Нийт дүн</b>	<b>4858.1</b>	<b>5243.5</b>	<b>385.4</b>

Эх сурвалж: Гурванбулаг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Оны эхний болон эцсийн богино хугацаат өр төлбөрийн үлдэгдлийн дийлэнх хувийг ажиллагсадтай холбоотой өглөг эзэлж байгаа нь төсөвт байгууллагын төсвийн захирагч, нягтлан бодогч нар Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т заасан “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажилладаггүй, ажиллагсад оны эцэст жилийн үр дүнгийн урамшуулал олгохдоо түүнд ногдох ХХОАТ, НДШ-ийг төлөөгүйгээс оны эцэст өглөг үүссэн байна.

Тухайлбал:

- Ерөнхий боловсролын сургууль оны эцэст ХХОАТ-ын 1929.0 мянган төгрөгийн өглөгтэй гарсан;
- Цэцэрлэг оны эцэст 1085.8 мянган төгрөгийн ХХОАТ-ын, 29.1 мянган төгрөгийн үйлдвэрчний эвлэлийн татварын өглөгтэй гарсан;
- Соёлын төвийн оны эцэст 70.6 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөгтэй гарсан;
- Эрүүл мэндийн төвийн оны эхний үлдэгдлийн 3095.9 мянган төгрөг нь ажиллагсад өгөх өглөг, НДШ, ХХОАТ-ын өглөг, 547.9 мянган төгрөг нь ҮЭ-ийн өглөг байсан;
- ИТХ-ын оны эхний үлдэгдлийн 1200.6 мянган төгрөгөөс 322.9 мянган төгрөг нь НДШ-ийн, 108.6 мянган төгрөг нь ҮЭ-ийн өглөг байсан;
- ЗДТГ оны эцэст 52.9 мянган төгрөгийн өглөгтэй гарсан байна.

Иймд цаашид үр дүнгийн урамшууллыг олгохдоо татвар, НДШ-ийг суутгалыг гүйлгээ хийсэн тухай бүрд бүрэн тооцон, шилжүүлж, төсөвтөө багтаан ажиллаж, оны эцэст өглөггүй ажиллах шаардлагатай байна.

**Хүснэгт 11. Өглөгийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/**

№	Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Үүнээс:		
				Ажиллагсадтай холбоотой	Байгууллагад төлөх	Бусад өглөг
1	Сургууль	12.4	2,161.2	1,929.1	228.1	4.0
2	Цэцэрлэг	1.7	1,121.8	1,115.0	-	6.8
3	Эрүүл мэндийн төв	3,643.9	1,458.0	912.6	545.5	-
4	Соёлын төв	-	156.5	70.7	-	0.1
5	ИТХ	1,200.2	188.9	-	-	188.9
6	ЗДТГ	-	157.2	157.2	-	-
<b>ДҮН</b>		<b>4,858.2</b>	<b>5,243.6</b>	<b>4,184.5</b>	<b>773.6</b>	<b>199.8</b>

Эх сурвалж: Гурванбулаг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Аудитын явцад өмнөх оны өглөгийн барагдуулалтыг байгууллага тус бүрээр шалгахад дараах өглөгийг тодруулж, 2020 онд бүрэн барагдуулах нь зүйтэй байна. Үүнд:

1. Ерөнхий боловсролын сургуулийн өмнөх оны 4.0 мянган төгрөгийн өглөг нь эзэн холбогдогч тодорхойгүй гэсэн шалтгаанаар барагдаагүй;
2. Эрүүл мэндийн төвийн ажиллагсадтай холбоотой оны эхний 3095.9 мянган төгрөгийн өглөгөөс 912.6 мянган төгрөгийн өглөг барагдаагүй байна.

**2.8.9 Засгийн газрын хувь оролцоо**

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4094063.6 мянга, эцсийн үлдэгдэл 4335318.1 мянган төгрөг болж, 241254.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн байна.

**Хүснэгт 12. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1852532.3	1853548.7	1016.4	45.2
Хуримтлагдсан үр дүн	1564854.8	1806109.3	241254.5	38.2
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	676676.5	675660.1	-1016.4	16.5
<b>Дүн</b>	<b>4,094,063.60</b>	<b>4,335,318.10</b>	<b>241,254.50</b>	<b>100</b>

Эх сурвалж: Гурванбулаг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Соёлын төвийн санхүүгийн тайлангийн оны эхний үлдэгдлийн хөрөнгийн дахин үнэлгээ, засгийн газрын оруулсан капиталыг 1016.4 мянган төгрөгийг Э-тайланд зөрүүтэй оруулсныг аудитын явцад залруулав.

**2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Аймгийн ИТХ-ын 2018 оны төсөв батлах тухай 14/03 дугаар тогтоолд зааснаар Гурванбулаг сумын Засаг дарга тайлант онд улсын төсөвт 2700.0 мянга, аймгийн төсөвт 80600.0 мянга, нийт 83300.0 мянган төгрөгийн орлого оруулахаар батлагдсанаас гүйцэтгэлээр 81057.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 106.7 хувиар биелүүлсэн байна.

**Хүснэгт 13. Төвлөрүүлэх орлого / мянган төгрөг/**

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1.Улсын төсөвт төвлөрүүлэх орлого</b>	<b>2700</b>	<b>2854.1</b>	<b>154.1</b>	<b>105.7</b>
1.1.Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	900.0	926.0	26.0	102.9
1.2.Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,400.0	1,400.9	0.9	100.1
1.3.Агаарын бохирдлын төлбөр	400.0	527.2	127.2	131.8
<b>2.Аймгийн орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого</b>	<b>80,600.0</b>	<b>78,202.9</b>	<b>(2,397.1)</b>	<b>1.0</b>
2.1.Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар	70,000.0	70,599.3	599.3	100.9
2.2.Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	600.0	618.0	18.0	103.0
2.3.Газрын төлбөр	5,000.0	2,604.5	(2,395.5)	52.1
2.4.Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар	5,000.0	4,381.1	(618.9)	87.6
<b>Нийт дүн</b>	<b>83,300.0</b>	<b>81,057.0</b>	<b>(2,243.0)</b>	<b>106.7</b>

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Татварын хэлтсээс ирүүлсэн татварын орлогын мэдээ

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлж ажилласан бөгөөд аймагт төвлөрүүлэх орлогоос газрын төлбөр 47.9 хувиар тасарсан газрын төлбөр төлөхөөр гэрээ байгуулсан 2 аж ахуйн нэгжээс нэг нь татвараа төлөөгүйтэй, авто тээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар 12.4 хувиар тасарсан нь аймгийн дугааргүй тээврийн хэрэгсэл харьяа нутгийн татварын байгууллагад татвараа төлсөнтэй холбоотой байна.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2018.12.14-ний өдрийн 10/03 тоот тогтоолоор сумд төвлөрөх татварын орлогыг 42450.0 мянга, татварын бус орлогыг 2500.0 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 76173.1 мянган төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 173.3 хувиар биелүүлсэн байна.

**Хүснэгт 14. Сумын орон нутгийн орлого /мянган төгрөг/**

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1.Татварын орлого</b>	<b>41,450</b>	<b>72,553</b>	<b>31,103</b>	<b>175.04</b>
1.1.ИОТХ	6,500.0	7,338.8	838.8	113
1.2. Хадгаламжийн хүүгийн орлого	22,000.0	30,879.6	8,879.6	140
1.3. Бууны татвар	3,850.0	3,595.7	(254.3)	93
1.4.Улсын тэмдэгтийн хураамж	1,000.0	3,486.2	2,486.2	349
1.5.Ан амьтны нөөц ашигласны төлбөр	-	25,600.0	25,600.0	-
1.6.Хог хаягдлын үйлчилгээний төлбөр	2,500.0	595.8	(1,904.2)	24
1.7.ТТАМАТөлбөр	5,300.0	757.0	(4,543.0)	14
1.8.Нохойны татвар	300.0	300.0	-	100
<b>2.Татварын бус орлого</b>	<b>2,500</b>	<b>3,620</b>	<b>1,120</b>	<b>144.80</b>
2.1.Хүү торгуулийн орлого	2500.0	3620.0	1,120.0	144.8
<b>Нийт дүн</b>	<b>43,950.0</b>	<b>76,173.1</b>	<b>32,223.1</b>	<b>173.32</b>

Эх сурвалж: Гурванбулаг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71702, 71801, 71802, 71806, 72101 гэсэн кодтой 9 хөтөлбөрт зориулан 2092012.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1985147.6 мянган төгрөгийг урсгал зардалд, 106864.4 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1273520.3 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс, 22185.2 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилтээс, 88821.2 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 551325.9 мянган төгрөгийг сумын орон нутгийн төсвөөс, 110549.2 мянган БНА-2020/1/СТА-ТТЗ

төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 600.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос, 45010.2 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс авах санхүүжилт, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтийг бүрэн авч, Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилтээс 4744.8 мянган төгрөгийн санхүүжилт дутуу авсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогоор сум хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлтийн орлогоор 110549.2 мянган төгрөг оруулахаас 26123.9 мянган төгрөг оруулж, батлагдсан төсвөөс 84425.3 төгрөгөөр тасарсан нь Сум хөгжүүлэх сангийн зээлийн төлөлт хангалтгүй байгаатай холбоотой ба тайлант онд шинээр зээл олгоогүйтэй байна.

Туслах үйл ажиллагааны орлогоор сумын ЗДТГ-ын өөрийн орлогоор 600.0 мянган төгрөг төвлөрүүлж, гүйцэтгэлээр 100.0 мянган төгрөг оруулж, төлөвлөгөө 500.0 мянган төгрөгөөр тасарсан байна.

Иймд цаашид сум хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлтөд онцлон анхаарч ажиллаж, төсөвт байгууллагууд өөрийн орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлж ажиллах шаардлагатай байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1918532.0 төгрөг буюу 91.7 хувьтай байгаа нь тогтмол зардал 20443.7 мянга, хангамж, бараа материалын зардал 3711.3 мянган төгрөгөөр хэмнэгдсэн, эд хогшил худалдан авах зардал 4554.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн, Сум хөгжүүлэх сангаас тайлант онд зээл олгоогүйгээс бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 136011.6 мянган төгрөгөөр хэмнэгдсэн зэрэг нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

*Хүснэгт 15. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөг/*

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Засаг даргын Тамгын газар	272583.2	272072.7	510.5	99.8
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	64121.9	63717.8	404.1	99.4
Ерөнхий боловсролын сургууль	794101.9	777088.3	17013.6	97.9
Цэцэрлэг	244080.8	243608.3	472.5	99.8
Эрүүл мэндийн төв	382577.8	377832.8	4745.0	98.8
Соёлын төв	90165.8	82703.6	7462.2	91.7
Орон нутгийн хөгжлийн сан	106864.4	88821.2	18043.2	83.1
Сум хөгжүүлэх сан	137516.2	26123.8	111392.4	19.0
<b>Нийт дүн</b>	<b>2092012.0</b>	<b>1931968.5</b>	<b>160043.5</b>	<b>92.3</b>

Эх сурвалж: Гурванбулаг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

**Нэмэлт төсөв:** Тайлант онд дээд шатны төсвийн захирагчаас 83698.3 мянган төгрөгийн нэмэлт бүрдүүлж бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид 67536.7 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдлийн 3113.0 мянган төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд, 13048.7 мянган төгрөгийг аймгийн төрийн санд төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 16. Нэмэлт төсвийн судалгаа /мянган төгрөг/*

Байгууллагын нэр	Санхүүжилт	Зарцуулалт	Төвлөрүүлсэн	
			Аймаг	Сум
Засаг даргын Тамгын газар	67070.2	63966.7	0.0	3103.5
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1900.0	1900.0	0.0	0.0
Соёлын төв	1679.5	1670.0	0.0	9.5
Эрүүл мэндийн төв	39.7		39.7	0.0
Сургууль	13009.0	0.0	13009.0	0
<b>Нийт дүн</b>	<b>83698.4</b>	<b>67536.7</b>	<b>13048.7</b>	<b>3113.0</b>

Эх сурвалж: Гурванбулаг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Эрүүл мэндийн төвийн нэмэлт санхүүжилтийн дансаар орсон сорьц тээвэрлэх зардлын 39.7 мянган төгрөгийн гүйлгээг оны эцэст хийсэн боловч дансанд буцаж орсон, Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн багш нарын бичсэн төслийн санхүүжилтийн 13009.0 мянган төгрөгийг тавилга эд хогшил худалдан авах аж ахуйн нэгж тодорхойгүй байсны улмаас зарцуулаагүй төсөвт төвлөрүүлсэн байна.

## **2.10. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

### **2.10.1 Орлогын данстай холбоотой асуудал**

Аймагт төвлөрүүлэх газрын төлбөрийн орлогыг тайлант онд 5000.0 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 2604.5 мянган төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөө 2395.5 мянган төгрөгөөр тасарсан нь сумын Засаг даргатай "Ашигт малтмалын зориулалтаар газар ашиглах" гэрээ байгуулсан "Жи Эс Би Ресурс" ХХК газрын төлбөрийн 2215.9 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.

Энэ нь Эрх ба үүрэг, Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Гурванбулаг сумын Засаг дарга, "ЖИ ЭС БИ РЕСРУС" ХХК-ийн захирал нарын хооронд байгуулсан ашигт малтмалын зориулалтаар газар ашиглах гэрээ тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоов.

### **2.10.2. Балансын данстай холбоотой асуудал**

Төсөвт байгууллагуудын бараа материалын дансны эхний болон эцсийн үлдэгдлийг тулган шалгахад сумын Ерөнхий боловсролын сургууль бичиг хэргийн материал дансанд 600.0 мянган төгрөгийн принтер, 800.0 мянган төгрөгийн өнгөт принтер зэрэг үндсэн хөрөнгийг бүртгэсэн байна.

Энэ нь Үнэн зөв байдал, Үнэлгээ гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна УСНББОУС 17, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар батлагдсан дансны зааврын үндсэн хөрөнгийн 4.30 дахь хэсгийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөв.

## **2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ**

2.10.1. Дуусаагүй барилга байгууламж дансанд 20000.0 мянган төгрөгийн эхний үлдэгдэл байгаа нь 2018 онд сумын ОНХС-ийн хөрөнгөөр баригдсан парк бүртгэлтэй байгаа ба 2019 онд нэмж 3770.0 мянган төгрөгийн мал нядалгааны хашааг нэмж бүртгэснийг тодруулж үзэх шаардлагатай.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Гурванбулаг сумын Засаг дарга Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 148 мэдээллийг хугацаанд нь, 8 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Шилэн дансны мэдээллийг шалгахад сумын лого байрлах газарт албан хаагчийн зургийг байршуулсан тул засах шаардлагатай байна.

№	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	13	13	11	2	
2	Хагас жил	3	3	3		
3	Улирал бүр	2	8	8		
4	Сар бүр	5	60	60		
5	Тухай бүр	6	72	66	6	
	Нийт	29	156	148	8	

**2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Гурванбулаг сумын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд ахлах аудитор Б.Азбаяр аудит хийж, аудитаар акт , албан шаардлага зөвлөмж өгөөгүй байна.

**2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Гурванбулаг сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Гурванбулаг сумын Засаг даргын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

#### **4. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Гурванбулаг сумын Засаг даргын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ**

##### **3.1 Балансын данстай холбоотой асуудал**

###### **3.1.1 Илрүүлэлт:**

Сумын төсөвт байгууллагуудын өмнөх оны авлага, өглөгийн барагдуулалтыг тулган шалгахад ЕБС өмнөх оны 872.2 мянга, Эрүүл мэндийн төв 157.3 мянга, ИТХ 3000.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүйгээс авлагын насжилт өндөр гарч байна.

Мөн оны эцэст ажиллагсдад жилийн үр дүнгийн урамшуулал олгохдоо татвар, НДШ-ийг бүрэн тооцож олгоогүйгээс татвар, НДШ-ийн өглөг үүссэн авлага, өглөгийг барагдуулаагүй байна.

Энэ нь Үнэн зөв байдал, Эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэснийг зөрчсөн байна.

###### **3.1.2 Эрсдэл:**

Насжилт өндөртэй авлага өглөгийг барагдуулаагүй байх.

###### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтыг хэрэгжүүлж оны эцэст авлага, өглөггүй ажиллах, өмнөх оны авлага, өглөгийн эзэн холбогдогчийг тогтоож, хууль хяналтын байгууллагад шилжүүлж, авлага, өглөгийг бүрэн барагдуулах.

###### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Аудитаар илэрсэн алдааг зөвшөөрч байна.

### 3.2 Балансын данстай холбоотой асуудал

#### 3.2.1 Илрүүлэлт:

Санхүүгийн нэгтгэсэн тайланд оны эхэнд 18325.0 мянган төгрөгийн мал амьтан байгааг тодруулж шалгахад сумын ЕБС-д 213 хонь, 87 ямаа, Цэцэрлэгт 80 хонь, Эрүүл мэндийн төвд 2 үхэр бүртгэлтэй байхад 2019 онд малын нас дэвшилтийн хөдөлгөөнийг бүртгээгүй, түүхий эдийн орлого дансанд оруулаагүй байна.

Энэ нь Тохиолдсон байх, Үнэн зөв байдал, Үнэлгээ гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийг тус тус зөрчсөн байна.

#### 3.2.2 Эрсдэл:

Мал амьтдын хөдөлгөөний бүртгэл хийгээгүй байх, туслах аж ахуйн орлогыг төвлөрүүлээгүй байх.

#### 3.2.3 Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайланд бүртгэлтэй малын нас дэвшилтийн орлого, зарлагыг холбогдох хууль, журмын дагуу зах зээлийн ханшаар үнэлж бүртгэн, оны эцэст малын тоог А дансаар баталгаажуулж, тооллогын бүртгэлд хавсарган баталгаажуулж аудитын байгууллагад ирүүлж байх.

#### 3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар илэрсэн алдааг зөвшөөрч байна.

### 3.3 Балансын данстай холбоотой асуудал

#### 3.3.1 Илрүүлэлт:

Сум хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгохдоо зээлийн хүүгийн авлагыг анх олгосон жилдээ 3 жилээр бүртгэсэн ба сангаас олгосон зээлийн эргэн төлөлт хангалтгүй, хугацаа хэтрэлт ихтэй, эргэн төлөлтөд тавих дотоод хяналт сул байна.

Аудитын явцад сумын ОНХС-аас малжуулах зээл авсан иргэдийн судалгааг гаргуулахад 31 малчинд 50-70 бог олгож, оны эцэст 129000.0 мянган төгрөгийн авлагыг бүртгэсэн ба малжуулах зээл авсан иргэдийн зээлийг тухайн онд төлсөн, дараагийн зээл авсан иргэдээр бүртгэлийг шилжүүлэн санхүүгийн тайланд орлого, зарлагаар бүртгээгүй байна.

